

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2025 ОНЫ НӨХӨН СОНГУУЛЬД ОРОЛЦСОН НАМ, ЭВСЭЛ, НЭР ДЭВШИГЧИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАНГ ХЯНАЖ, НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Арвайхээр хот
2025 он

Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга бөгөөд Тэргүүлэх аудитор О.Батжаргал
Утас: 70323253, цахим хаяг:

Аудитын менежер П.Хорлоосүрэн, Утас: 70323108,
цахим хаяг: Khorloosuren@audit.gov.mn

Ахлах аудитор: Ө.Ринчинмядаг, Утас: 70323833,
цахим хаяг: Rinchinmyadagu@audit.gov.mn

Аудитор: Э.Энхбаяр, Утас: 70323108,
цахим хаяг: Enkhbayare@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой
нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.
Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.....	3
1.1. Аудитын үндэслэл, зорилго	3
1.2. Аудитын хамрах хүрээ	3
1.3. Арга зүй	3
ХОЁР. СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАН.....	3
2.1. Төрийн аудитын байгууллагад ирүүлсэн сонгуулийн зардлын тайлан	3
ГУРАВ. ДҮГНЭЛТ	4

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар

НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1. Аудитын үндэслэл, зорилго

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-д “Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлэх бөгөөд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ.” гэж заасны дагуу аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг хянаж нэгтгэн, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, нийтэд мэдээлнэ.

1.2. Аудитын хамрах хүрээ

Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын 2 дугаар тойрогт зохион байгуулагдсан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан ирүүлсэн сонгуулийн зардлын тайлан, түүнд хавсаргасан аудитын дүгнэлт, дэлгэрэнгүй тайлан, аудит хийгдсэн сонгуулийн зардлын тайлангийн маягт, харилцагч банкны дансны хуулга болон бусад шаардлагатай баримт, материалыг хамруулсан болно.

1.3. Арга зүй

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, АДБОУС 100, 400, 4000, Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/30 дугаар тушаалаар баталсан “Аймаг, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах журам”-ыг үндэслэн нам, эвсэл, нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө, нам, эвслээс оруулсан хөрөнгө, иргэн, хуулийн этгээдээс авсан хандив түүний зарцуулалтын тайланг шалгаж, аудит хийсэн хуулийн этгээд, нам, эвсэл, нэр дэвшигчээс лавлагаа, тодруулга авч, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж тайланг бэлтгэсэн.

ХОЁР. СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАН

2.1. Төрийн аудитын байгууллагад ирүүлсэн сонгуулийн зардлын тайлан

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3-т заасны дагуу Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын 2 дугаар тойрогт зохион байгуулагдсан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд нэр дэвшсэн нийт 2 нам, 2 нэр

дэвшигч нь Сонгуулийн тухай хуульд заасны дагуу сонгуулийн зардлын тайлангаа аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан төрийн аудитын байгууллагад хүргүүлэхээр үүрэгтэй. Гэвч уг үүргээ биелүүлээгүйгээс 1 нам, 1 нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлангаа аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан ирүүлээгүй байна.

Мөн Сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.3-т "Нам, эвсэл болон нэр дэвшигчийг сонгуульд оролцуулахаар бүртгэх тухай шийдвэр гарснаас хойш энэ хууль болон банкны хууль тогтоомжид нийцүүлэн сонгуулийн зардлын дансыг нээлгэнэ" гэж заасныг зөрчиж, 1 нам, 1 нэр дэвшигч сонгуулийн зардлын данс нээлгээгүй байна.

Иймд Сонгуулийн зардлын данс нээлгээгүй болон тайлангаа ирүүлээгүй нам, нэр дэвшигчийн жагсаалтыг Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.3, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.22-т заасны дагуу аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн болно.

ГУРАВ. ДҮГНЭЛТ

Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын 2 дугаар тойрогт зохион байгуулсан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд нам, эвсэл, нэр дэвшигчийн аудитын хуулийн этгээдээр баталгаажуулан ирүүлсэн зардлын тайланг хянаж, дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Сумын 2 дугаар тойрогт зохион байгуулсан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон Нарийнтээл сумын Монгол Ардын Нам болон тус намаас нэр дэвшигч нь сонгуулийн зардлын данс нээлгээгүй байна.
2. Сумын 2 дугаар тойрогт зохион байгуулсан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон Нарийнтээл сумын Ардчилсан Нам болон тус намаас нэр дэвшигч нь сонгуулийн зардлын тайлангаа ирүүлээгүй байна.

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР





ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2025 оны 08 сарын 14 өдөр

Дугаар 1124

Арвайхээр сум

Нийцлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны 10 дугаар сарын 5-ны өдрийн А/102 дугаар “Эрх шилжүүлэх тухай” тушаалын дөрөвдүгээр хавсралтын 1.4 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нарийнтээл сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, нэгтгэсэн нийцлийн аудитын тайланг хавсралтаар баталгаажуулсугай.

2.Аудитын тайланг Өвөрхангай аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлэхийг ахлах аудитор (Ө.Ринчинмядаг)-д үүрэг болгосугай.

3.Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг аудитор (Э.Энхбаяр)-д үүрэг болгосугай.



О.БАТЖАРГАЛ

Монгол улс, Өвөрхангай аймаг
Арвайхээр сум, Нутгийн удирдлагын ордон
Утас: +976 70323253, 70323833, 70323108

Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn, цахим хуудас: www.audit.mn